

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 06 дугаар сарын 21

Дугаар 72

Улаанбаатар хот

“Нийтлэг үйлчилгээний газар-1, 2, 3, 4” ОНӨААТҮГ-ыг
татан буулгах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.16, 20.3 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван хоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор Баянзүрх дүүргийн орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болох “Нийтлэг үйлчилгээний газар 1, 2, 3, 4” ОНӨААТҮГ-ыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх сонгон шалгаруулалтын үр дүн гарах хүртэлх хугацаанд үйл ажиллагааг үргэлжлүүлж, татан буулгасугай.

2. “Нийтлэг үйлчилгээний газар-1, 2, 3, 4” ОНӨААТҮГ-уудыг татан буулгах ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны А/44 дүгээр тогтоолын дагуу сонгон шалгаруулалтаар шалгарч дүүргийн нутаг дэвсгэрт хог тээврийн үйлчилгээ үзүүлж буй 2 мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг хэвээр үргэлжлүүлсүгэй.

4. Хог хаягдлыг ачиж, цэвэрлэх, тээвэрлэх үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шуурхай зохион байгуулж, явц үр дүнг тухай бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахыг дүүргийн Засаг дарга (Н.Баярмөнх)-д даалгасугай.

5. Тогтоол батлагдсантай холбогдуулан Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны А/44 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Ч.Мэндсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА

А.БАЯР

Баянзүрх дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06
дугаар сарын-ний өдрийн арван
хоёрдугаар хуралдааны дугаар
тогтоолын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Г.Жаргалсайхан
Баянзүрх дүүргийн Засаг даргын орлогч

Гишүүд:

И.Баттөгс
Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын
газрын дарга

Б.Уянга
Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын
газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн
дарга

Б.Мөнгөншагай
Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын
газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Э.Энх-Очир
Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн
дарга

Д.Өлзийдэмбэрэл
Нийтлэг үйлчилгээний газар-1 ОНӨААТҮГ-
ын дарга

Ц.Ууганбаяр
Нийтлэг үйлчилгээний газар-2 ОНӨААТҮГ-
ын дарга

Т.Энхжин
Нийтлэг үйлчилгээний газар-3 ОНӨААТҮГ-
ын дарга

Нийтлэг үйлчилгээний газар-4 ОНӨААТҮГ

Нарийн бичгийн дарга:

Н.Билэгсайхан
Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын
газрын Тохжилт, нийтийн аж ахуйн
хэлтсийн дарга